

ХАНДЖАМЦЫН ДАШДОНДОВ

(1929-2003)

ХААИС-ийн Эдийн засгийн судалгааны төвийн эрхлэгч, Хөдөө аж ахуйн эдийн засгийн чиглэлээр боловсролын доктор, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга, эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийн академич **Ханджамцын Дашдондов** 2003 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр хүнд өвчний улмаас таалал төгслөө.

Х.Дашдондов нь 1929 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Архангай аймгийн Хотонт сумын нутаг "Цагаан сүмийн гол" гэдэг газар төржээ. 1945-1948 онд Улаанбаатар хотын Худалдааны техникум, 1948-1951 онд Багшийн дээд сургуулийг тус тус төгссөн байна.

Х.Дашдондов 1953-1958 онд Москва хотын Эдийн засгийн дээд сургуульд суралцан эдийн засагч мэргэжлээр төгсжээ. 1948-1961 онд Улсын Төлөвлөгөөний Комисст мэргэжилтэн, хэлтсийн дарга, 1967-1968 онд орлогч даргаар ажиллаж байв. 1961-1965 онд Москва хотын М. В. Ломоносовын нэрэмжит улсын их сургуулийн аспирантурт суралцаж, эдийн засгийн ухааны дэд доктор, 1971-1974 онд докторын зэрэг хүртсэн байна. 1968-1970 онд Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэнгийн САА-н даргаар ажиллаж байв.

Тэрээр 1965-1967 онд ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1970-1982 онд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, орлогч захирал, захирал, 1986-1998 онд ШУА-ийн Дорно дахины болон Олон улс судлалын хүрээлэнд орлогч захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1982-2003 онд ХААИС-д тэнхмийн эрхлэгч, төвийн эрхлэгч, төслийн удирдагчаар ажиллаж байсан юм.

Профессор Х.Дашдондовын шинжлэх ухааны болон дээд боловсролын салбарт гаргасан амжилтыг төр, засгаас өндрөөр үнэлж, ардын хувьсгалын 50, 60, 70, 80 жилийн ойн медалиуд, "Шинжлэх ухааны тэргүүний ажилтан" цол, тэмдэг, "Хөдөлмөрийн хүндэт медаль" болон "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор тус тус шагнаж байжээ.

Талийгаачийн ажилсаг, хүнлэг энэрэнгүй, нөхөрсөг тусч, ноён нуруутай, ухаалаг зан чанар нь бидний сэтгэл, зүрхэнд үүрд дурсагдах болно. Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийлье.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Санхүү эдийн засгийн яам

Хүнс, хөдөө аж ахуйн яам

Шинжлэх ухааны академи

Хөдөө аж ахуйн их сургууль

ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль

МУИС-ийн Эдийн засгийн сургууль

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн